



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

Аудитын дүгнэлт, зөвлөмжийг
хэрэгжүүлэх арга хэмжээний тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 44 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороодын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн аудитын дүгнэлтээр илэрсэн зөрчил, дутагдлыг дахин гаргахгүй ажиллах, зөрчил дутагдал гаргасан Багануур дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга Ж.Болдбаатар, нягтлан бодогч Б.Наранцэцэг, Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга Ш.Бямбасүрэн, нягтлан бодогч Л.Цоггэрэл, Налайх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга Д.Мөнхбаяр, нягтлан бодогч Д.Буян-Аривжих, Сүхбаатар дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга М.Алтангэрэл, нягтлан бодогч О.Дэмбэрэлсүрэн, Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга Д.Энхбаяр, нягтлан бодогч Г.Дэлгэрмаа, Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга Ц.Ганболд, нягтлан бодогч Г.Ууганбаяр, Багахангай дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга Г.Жамсран, нягтлан бодогч Ц.Хажидмаа нарт сануулах арга хэмжээ авсугай.

3. Монгол Улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон санхүүгийн тайлан гаргах талаар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, санаачлагатай ажиллахыг дүүргүүдийн Биеийн тамир, спортын хороодын дарга нарт даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД